

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сэрээнэнгийн Чүлтэм	Дугаар	L090
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Баян-Овоо
Төрсөн газар	Баян Овоо сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Вангийн хийд ба Жавхлантын хийд, Далтын шүтээн, Баруун гуут, Лаансын Ганжуурын хийд, Зүүн гуутын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭБО 115, ХЭБО 113 СБТЦ 063, СБТЦ 059, СБТЦ 060
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Баян Овоо сумын Вангийн хийд ба Жавхлантын хийд, Далтын шүтээн Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Баруун гуут, Лаансын Ганжуурын хийд, Зүүн гуутын хийд
- Баян-Овоо сум маань хуучин засаг захиргааны хуваариар ямар хошуу байсан вэ?
Хуучин Далай вангийн хошуу гэж байсныг Мөнххаан уулын хошуу болгосон. Үүнийг сүүлд нь нутгийн захиргаа байгуулахад бүтэн хагасаар 7 хэсэг болгосон. Энд Баян-Овоо сум бүтэн сумаараа тасарсан. Ийм газар байгаа юм.
-1937,1938 оноос өмнө энэ нутагт байсан хийдүүдийн талаар?
Анх энэ Баян-Овоо сум байгуулагдахдаа Хөндөл ухаа гэдэг газар анх байгуулагдсан. Одоо энэ Түмэнцогт сум байгаагийн зүүн хойно байдаг ухаагийн энгэр дээр анх байгуулагдсан юм. Тэнд Зүүн Гуутын хийд гэдэг газар Баян-Овоо сум анх байгуулагдсан юм. Тэрнээс зүүн хойш одоо энэ зүүн урд Баруун гуутын хийд гэж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хэрлэнгийн урд талд жаахан хийд байсан. Манайх тэнд нутаглаж байсан айл. Зүүн урагшаа Баянхааны хоолой гэдгээс нааш Хамжлагын хийд гэж бас нэг хийд байсан. Хөндлөн Ухаагаас баруун урагш одоо Баян-Овооноос баруун тийш Лаансын хийд гэж байсан. Нэлээн баруунтшлаад Цээлийн Эрдэнэ уул гэж байгаа газар тэнд Эрдэнэ уулын хийд гэж байсан. Тэрнээс урагш Мөнххаан уулын баруун хойд ард Цээлийн хийд гэж жаахан хийд байсан. Энүүхэн зүүн урагшаа байсан хийдийг Баруун гуутын хийд гэдэг. Сүм байсан нь Зүүн гуутын хийд гэдэг нэртэй. Зүүн урд Баянхааны хоолойд байсан хийдийг Хамжлагын хийд гэдэг юм. Баян-Овооноос баруун талд байсан хийд бол Лаансын хийд гэж байсан. Мөнххааны чинь Хошуу хийд гэж их том хийд байсан. Тэрнээс хойш Хоолой хүдгийн хийд гэж байсан даа. За ийм л хийдүүд байсан даа.

-Баян-Овоо сумын төв дээр байсан Вангийн хийдийн тухай?

Энэ сүм байгаа маань хуучин Хошой Чин вангийн хошуу гэдэг нэртэй ноёнттой тийм газар байсан юм. Баян-Овоо сүм тэр урд байсныг энүүгээр анх утас, зам тавиад тэгээд нааш нь нүүлгээд хуучин Хошой Чин вангийн нутаг дээр авчирсан юм.

-Хошуу бургасны урд дээр байсан хийд чинь ямар хийд вэ?

Баруун гуутын хийд. Голынхоо урд дээр. Довжооны хэдэн чулуу бий. Би тэнд сууж байсан. Би тэнд төрсөн тэгээд 18 нас өнгөртөл тэнд байсан.

-Баруун гуутын хийдийн тухай ярьж өгөөч?

Баруун гуутын хийд 2 модон дугантай, жаахан хийд байсан. Зуны их хурал гээд тэр хурлаа хурахын үест даавуу бүрээстэй гэр дуганууд барьдаг тэгээд тийм 5 дугантай болж хурлаа хурдаг. Зуны цагийн хуралд 100-аад лам цугладаг байсан. Ерөнхийдөө нэг 70, 80-аад ламтай байсан байх. Би 9 настай лам болж тэр хийдэд оролцож тэгж байсан. Сүүлдээ 13-тайдаа хурлын уншлага гэдгийг заалгаж дуусгаад тэгээд би Баруун гуутын хийдийн бурхан тахилыг хариуцдаг, өдөр тутамдаа жаахан хурал ном уншдаг тийм байсан. Тэгсээр байгаад 18-тай болж хар болж анхны байгуулагдаж байсан морин станцад орсон.

-Голын хойд талд, Баянхошуу энэ тэрээр хийд байсан уу?

Үгүй.

Шажин хурахад хийд байсан уу?

Цагаан байшин, Далтын суурин ч гэж нэрлэдэг нэг ганцхан байшинтай жаахан хурал дуган байсан.

- Тэр Далтын шүтээн мөн үү?

Тийм. Ганц хоёрхон ламтай тийм газар байсан.

-Далтын шүтээн хаана байсан гэнэ ээ?

Одоо тэр газар маань хаана байна вэ? Далт гэдэг уул уг нь бий л юмсан. Тэрний л энгэрт юмсан даа. Энүүхэн энэ зүүн урд байгаа биз дээ.

-Далт Хөтөл овоо гэж тэнд биз дээ?

Тийм ээ, Далт гэдгийн энгэр дээр л байсан юмсан.

- Хуучин нэгдлийн төв болгоно гээд энгэр дээр байсан тэр хавьд л байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тэр л орчим л доо. Би одоо мартчихаад сайн мэдэхгүй байна.Хавцалаас зүүн хойш, Бунхантаас баруун хойш тийм багцаанд бий.

-Баруун гуутын хийдийг хэдэн онд, хэн байгуулсан бэ?

Уул тэр хийдийг бий болгосныг мэдэхгүй. Эртний дээр үеийн л юм байгаа биз. Лам нар нь намайг байх үед олон солигдож байсан.

-Хамба лам нь хэн гэдэг хүн байсан бэ?

Хамгийн сүүлд байсан лам миний багш Лувсан гэдэг хүн байсан.Тэр лам ер нь лам нарыг хар болгоод ирэхэд багш маань хар болсон.Баригдаагүй. Лам нар баригдахын өмнө өөрөө Хэрлэн голд орж таалал болсон. Тэгээд хүмүүс уснаас нь гаргаж ч оршуулаагүй. Хэрлэнгээр улсууд яваад усанд нь дагууд нь түлхсээр байгаад Баруун гуутаас нэлээн доош нь гаргаад л орхисон доо. Тэгээд л тэр усандаа тэгж л үрэгдсэн байх.

-Хийдийн мяндагтангуудыг та санаж байна уу?

Одоо амьд хүн байхгүй. Миний сайн мэдэж байгаагаар, би таван настай төвд ном эхлүүлээд есөн настай сахилтай болж анх эхэлж хийдийн хуралд суусан юм. Тэр үеэс эхлээд бодоход Тэргүүн лам нь Дагдангэлэн гээд миний багш байсан.Тэр нутагтаа нас барсан. Цогт унзад гэж Лонгойн Шарав гэдэг лам байсан. Сүүлдээ хар болоод Баянтэрэм сум руу нүүгээд тэр нутагт байгаад тэндээсээ баригдсан юм гэнэ лээ. Дэд унзад нь Чой гэлэн гэдэг хүн байж байгаад нутгаасаа баригдсан. Дэд лам нь Гэндлодой гэдэг хүн байсан.Тэр хүн бол нутагтаа өөрөө нас барсан. Гэсгүй гэдэг нь Гэндлодой гэдэг хүн тэрүүгээр орж л байсан. Ёндогийн Шарав гэж гэсгүй байсан. Тэд баригдаагүй. Нас барцгаасан байх аа. Тушаалтай улсууд нь тийм л хүмүүс байсан даа.

-Баруун Гуутын хийдийн голлох хурал нь ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Өвлийн эхэн сарын 25-нд зулны хурал, өвлийн дунд сарын шинийн 7-нд бас зулны хурал гэж хурдаг байсан. Тэгээд цагаан сар маргааш гарна гэдэг битүүний шөнө хуучны хурал гэж шөнө хураад цагаан сарын өглөө тардаг байсан. Хаврын эхэн сарын 11-ээс эхлээд 5 хоногийн ерөөл хураад 15-нд тардаг байсан. Зуны эхэн сарын 15-нд нэг өдрийн хуралтай, зуны дунд сарын 17-нд бас нэг өдрийн хуралтай, зуны адаг сарын шинийн хоёрт хойно нь байгаа Хошуу бургас гэдэг бургасан овоог тахидаг. Эхлээд шинийн хоёронд овоог тахидаг. Шинийн 4-өөс их, бага хурал гэж нэрлэдэг даавуун бүрээстэй гэр дуганууд бариад таван хэсэг газар тасарч хурдаг байсан. Шинийн 4-өөс 15 хүртэл хураад 15-нд Майдараа эргээд дуусдаг байсан. Намар тогтмол биш Санжин жасаа гэж сангийн жасаа ухаантай нэг өдрийн хурал байдаг. Баруун Гуутын тогтмол хурлууд ийм байсан. Тэгээд сүүлийн үед бол хайлан гээд 45 хоногийн гэлэн гээд дандаа давхар сахилтай хүмүүс суудаг хурал хэдхэн жил лам нар саналаараа суусан. Тийм л хурал ном байсан даа. Би бурхан тахилыг хариуцдаг ёстой бүх юмыг нь мэддэг хүн байсан. Тэгээд одоо би 18-тай хар болсон. Хийдээ үрэгдэх үед байгаагүй. Баянтэрэм сумд өвсний станц гэдэгт ажилд томилогдоод тэнд явчаад байхад хийд маань байхгүй болчихсон байсан. Яг намайг явах үед хийдийг маань битүүмжилчихээд байсан.

-Хэдэн онд битүүмжилсэн бэ?

1937

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Баруун Гуутын хийд ямар сахиустай байсан бэ?

Гомбо гэж байсан. Тэрний дараагийнх нь Чадраабал. Энэ хоёр бурхан голлож байсан. Дээр нь 10-аад суумал бурхан байсан.

-Баруун Гуутын хийдийг хэний санаачлагаар байгуулсан бэ?

Мэдэхгүй.Хэдүйд байгуулсныг нь мэдэхгүй юм. Удсан л юм гэнэ лээ.

-Түвд нэр нь?

Гэлэргавжаалин гэдэг байсан.

-Баруун Гуутын хийдэд юу голлодог байсан бэ? Чойртой байсан уу?

Үгүй. Хөдөө газрын жижиг хийд байсан. Тогтмол, өдөр тутмын хурал энэ тэр гэж байгаагүй. Өдөртөө ганц цагийн нэг уншдаг юм байдаг. Тэрийг нь би насанд хүрсэн хойноо уншдаг байсан.

-Юу уншдаг байсан бол? Цогчэн юм уу?

Тэр Гомбо сахиусаа тахидаг байсан юм. Бага Гомбо гэдгийг нь уншдаг байсан. Бас хэнгэрэг цантай, хонх дамартай байсан. Бүгдийг нь зэрэг барих биш, би бол хонх дамрыг нь барьж нэг дуугаргаад, хэнгэрэг цангаа хавсарч нэг дуугаргаад л тэгээд л тэр номоо уншдаг. Сурчихсан юм болохоор судар ном нь дэргэд байж л байдаг сангаа тавиад л цээжээр уншдаг байлаа.

-Тэнд эрдэмтэй, алдартай лам нар байсан уу?

Тийм лам нар байхгүй ээ.Гавж гэвш зэрэг нь хөдөөний жижиг хийдэд байрин байхгүй. Дандаа томхон хошуу хийдэд л байна. Зүгээр хурлын уншлагын лам нар хурлаа хурахад цуглаад л тардаг тийм л юм байсан юм. Тэгэхлээр Баруун Гуутын лам нар харъяалсан газар нь нэг 60,70- аад л лам нар л байсан юм. Тэгээд зарим хуралд бол энд тэндээс өөр газраас лам нар энэ тэр ирнэ. Зарим хуралд бол тэр данстай лам нар бүгдээрээ ирэхгүй, хагас нь ирнэ. Янз бүр л байсан.

-Танай хийд ямар ямар хийдтэй холбоотой байв?

Баянхааны хоолойд байсан Хамжлагийн хийд, одоогийн Түмэнцогтын төв байгаагийн зүүн хойно нь байдаг урт ухаагийн энгэр дээр байсан Зүүн гуутын хийд, Баян-Овооноос баруунтаа Лаансын хийд гэж байсан. Тэр хийдүүдтэй харилцаатай байсан.

-Танай хийдэд төвд лам нар ирдэг байсан уу?

Байгаагүй. Манай Баруун Гуутын дэргэд бол нэг төвд байсан. Тэгэхдээ тэр хүн бол баруунтай нэлээн байдаг байсан. Хурал энэ тэр хурж байгаагүй.

-Танай хийд төвдийн хийдтэй харилцаа холбоо байсан уу?

За байсан гэх үү дээ. Мөнхзовуу гэж хаа ч байдаг юм,төвд орны л юм байгаа биз. Тэндэхийн дэгийн хурал гэж бас зарим нэг жаахан хурлууд энэ тэр байсан даа. Лхасмонлам гэдэг хурал, Дамжиг гэдэг хурал хоёр төвд дэгийн хурал юм гэнэ лээ. Тэрийг хурдаг лам их ховор байсан

—Танд өөр нэмж хэлэх юм байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бусад хийдүүдийн талаар бол хэлэх юм алга. Баянхааны хоолойд байсан Хамжлагийн хийдэд очиж хуралд нь сууж байсан. Бүсдыг нь мэдэхгүй.

-Вангийн хийдийн талаар?

Ваангийн хийд гэдэг бол өөр хошуу. Хуучин Хошой Чин Вангийн гэдэг хошууны гол хийд байсан газар. Манай сумын төв байгаа газар маань. өөр нутаг байсан газар. Энэ хийд ямар хуралтай байсныг мэдэхгүй. Өөр хошуу болохоор. Зуны адаг сарын 29-нд цам нь болдог байсан. Бид нутгаасаа Ваангийн цам үзнэ гээд тэр өглөөгөө морьтой гардаг байлаа. Манай нутаг Баруун гуутын хийд байсан газар маань эндээс 30 арай л хүрэхгүй. Бид тэндээсээ олуулаа өглөө хүрч ирчихээд өдөр Ваангийн хийдийн цамыг үздэг. Тэгээд хүн танихгүй хүний хошуу болохоор айлд орохгүй. Өдөр усан дээр очиж морио услана. Өөрснөө ус ууна. Тэгээд л орой нар шингэхийн багцаанд цам ч ордог, бид ч буцаад явчихдаг тийм л байсан.

- Ваангийн хийд хэдэн дугантай байсан бэ?

Энийгээ би сайн мэдэхгүй болоод байнаа. Өндөрхааны хийд энэ Ваангийн хийд хоёрын нэг нь л 7 дугантэй нэг нь 9 дугантэй байсан юм. Аль нь 7, аль нь 9 байсныг мэдэхгүй байна.

-Өндөрхааны хийд гэдэг маань ямар хийдээ хэлээд байна?

Одоо аймгийн төв.

-Гүндгаварлин уу?

Тийм. Би бол Өндөрхааны хийдийг мэдэхийн хувьд бол мэднэ. Бас хуралд нь очиж мөргөж, цав манзнаас нь хүртэж л явсан. Миний байсан Баруун гуутын хийд бол хоёрхон дугантай байсан. Нэг дуганаа нэлээн дээхнэ нэг мөнгө энэ тэр гарч ирээд тэгээд мөнгө төлөхийн тулд нэг дуганаа худалдчихсан.

-Далтын хийдийн талаар?

Далдын хийд гэдэг ердөө ганцхан байшин байсан. Ганцхан лам байдаг өдөртөө юм уншдаг л байсан юм гэнэ лээ. Далтын суурин ч гэдэг Цагаан байшин ч гэдэг тийм байсан.Тэгээд хийдүүд үрэгдэхийн үед Далтын хийдийн байшинг нүүлгэж авчраад Могойтын баруун хойд талд бариад байсан. Тэгээд Ваангийнхаа хийдтэй хамт л үрэгдсэн байх даа.

-Сужгарт барьсан юм уу? Дэгт дээр барьсан юм уу?

Могойтын баруун хойд талд л нэг байшин байсан. Баруун хойно нь ойрхон байсан даа.

-Баруун гуутын хийд ямархуу байдалтай хаагдав? Лам нар нь баригдаад хаагдав уу?

Лам нар нэг хэсэг нь баригдсан. Үлдсэн лам нар саналаараа хар болсон.

Чухам хийд маань бол тийзтэй, бичиг наалттай нэлээд удсан. Зарим нь нэлээд удаж байсан байх. Мөнхааны хийд бол манай хуучин хошуу хийд, хамгийн том хийд байсан.

-Мөнххааны хийдийн нэр нь юу гэдэг нэртэй хийд байсан юм бол?

Хийдийн нэрийг мэдэхгүй байна.

-Ваангийн хийд ямар нэртэй байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мэдэхгүй. Ойрын хийд дотроо Мөнххааны хийд хамгийн том нь байсан юм. 15 дугантай. Хамгийн том нь 36 баганатай хоёр дугантай байсан. Цогчэн дуган, Чойрын дуган гэж нэрлэдэг тийм байсан.